



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/ЧД

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 03/07 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааг иргэдэд ил тод, хүртээмжтэй хүргэх ажлыг төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

2.Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, гүйцэтгэлийн дагуу батлагдсан зардлаас санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100094

Аймгийн Засаг даргын 2021 оны 01...
дугаар сарын 29-ны өдрийн 4/40 дүгээр
захирамжийн хавсралт

ТӨВИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
БАЙГУУЛЛАГУУДААР 2021 ОНД ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН
ЗАРДЛЫН ХУВААРЬ

Д/д	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэр	Санхүүжилт /Мян.төг/
1	МҮОНТ-ийн Орон нутаг дахь сэтгүүлч	6000,0
2	“Соёмбо” телевиз	6000,0
3	“Хас” телевиз	6000,0
4	“Жи Эм” телевиз	6000,0
5	“Арвайхээр чөлөөт суваг” телевиз	6000,0
6	“Ноён-Уул” богино долгионы радио	4000,0
7	“Өвөрхангайн мэдээ” сонин	5000,0
8	“Өвөрхангай” сонин	3000,0
9	Монголын радиогийн сурвалжлагч	2000,0
10	Uvnews.mn сайт	2000,0
11	Montsame.mn	1000,0
12	Өв брэнд консалтинг ХХК	1500,0
13	Төвийн хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	9000,0
НИЙТ		57,500,0